



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн  
үеийн бэлэн байдлыг  
хангах тухай

Монгол Улсын хэмжээнд томуу, томуу төст өвчин (ТТӨ) нь тархвар судлалын 30 дугаар долоо хоногоос эхлэн нэмэгдэж, 38-39 дүгээр долоо хоног буюу 9 дүгээр сарын сүүлийн 7 хоногт идэвхжлийн түвшинд шилжиж, оргил үе нь 12 дугаар сарын дунд үе болон 1 дүгээр сарын эхээр тохиодог.

Сүүлийн 10 жилд дунджаар 512,720 хүн ТТӨ-ний улмаас амбулаториор хандаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан ба үүнээс 58,157 хүн амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ)-ын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, жил бүр 80-85 хүн нас бардаг. Түүнчлэн 2021/2022-2024/2025 оны томуугийн улирал харьцангуй удаан буюу дунджаар 39 долоо хоног үргэлжилсэн бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд ТТӨ-өөр жилд дунджаар 767,414 хүн өвчилж, АЗЦХХ-аар 77,420 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, өвчлөл өмнөх жилүүдтэй харьцуулахад 1.5-2 дахин нэмэгдэж, АЗЦХХ-ын улмаас нийт 66 хүн нас барсан байна.

ТТӨ-ний нийт тохиолдлын 60 хувь (460,450), АЗЦХХ-ын 80-90 хувийг (69,678) 14 хүртэлх насны хүүхэд, үүнээс 40-70 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл эзэлдэг. АЗЦХХ-ын шалтгаантай нас баралтын 27.7 хувь нь 5 хүртэлх насны хүүхдэд, 53.5 хувь нь 50-аас дээш насныханд бүртгэгддэг байна. Жил бүр хүн амын дунд томуугийн А(Н3N2), А(Н1N1)pdm09, В, амьсгалын замын синцитиаль вирус эргэлтэд орж, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн гол шалтгаан болдог.

Улирлын томуу болон амьсгалын замын синцитиаль вирус нь томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үндсэн шалтгаан болдог ба 5 хүртэлх насны хүүхдийн 31.5 хувь нь улирлын томуугийн вирус, 64.5 хувь нь амьсгалын замын синцитиаль вирусийн халдвар авч өвчилдөг.

ТТӨ болон АЗЦХХ-ын тандалтын тоон мэдээг ашиглан “олон эмгэг төрүүлэгч/олон хувилбар (Bayesian P-spline) загвар”-аар өвчний хандлагыг тооцоход ТТӨ-ний оргил үед долоо хоногт хамгийн багадаа 13,185, хамгийн ихдээ 42,449 хүн амбулаториор үйлчлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах бол АЗЦХХ-ын улмаас хамгийн багадаа 1,301, хамгийн ихдээ 4,653 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх урьдчилсан тооцоололтой байна.

Иймээс томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн тандалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, дэгдэлтийн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, өвчний хүндрэлээс сэргийлэх, халдвараас сэргийлэх, хяналтын дэглэмийг баримтлах, лабораторийн урвалж, оношлуурын тасралтгүй байдлыг хангаж ажиллахыг Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт ДААЛГАХ НЬ:

### **Нэг. Тандалт, хариу арга хэмжээний чиглэлээр:**

1.1. Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээний босго үзүүлэлтийг шинэчлэн, долоо хоног бүр тархалтын үе шатыг тодорхойлж, үе шат бүрт тохирох нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах;

1.2. Томуу, томуу төст өвчин болон бусад халдварт өвчний улирал угтуулан эсхүл халдварт өвчний тархвар зүйн нөхцөл байдалд өөрчлөгдөх бүрт хамтарсан эрсдэлийн үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх;

1.3. Сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн эмч нартай хамтран томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх (амны хаалт зүүх, гар угаах) арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.4. Цэцэрлэг, сургуулийн орчинд халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, гар угаах нөхцөлийг бүрдүүлэх;

1.5. Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөнүүдээс тархалтын үе шатнаас хамаарч, 5-10 сорьцыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 373 дугаар тушаалыг баримтлан харьяа Нэгдсэн эмнэлэг/Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн молекул биологийн лабораторид долоо хоног бүр хүргүүлэх;

1.6. Бүсийн болон салбар лабораториуд вирус судлалын тандалтыг тасралтгүй зохион байгуулахад шаардлагатай сорьц тээвэрлэх орчин, урвалж, оношлуурын тооцоог гаргаж, нөөцийг бүрдүүлэх, шинжилгээ хийж, тандалтын мэдээг долоо хоног бүр ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид ирүүлэх;

1.7. Вирус судлалын тандалтын шинжилгээг хийх боломжгүй онцгой тохиолдолд лавлагаа лабораторийн багтай тохиролцон тусгай хуваарийг гарган, гэрээ байгуулж, ажиллах;

1.8. Амьсгалын замын халдварын кластер өвчлөл, эмнэлзүйн өвөрмөц тохиолдол бүртгэгдэх, лабораторийн шинжилгээнд томуу, SARS-CoV-2 вирусийн шинэ хувилбар илэрсэн тохиолдолд ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгжид 24 цагийн дотор мэдээлж, эрсдэлийн үнэлгээг салбар хоорондын багтай хамтран хийж, голомтод шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулж, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.9. Шувуу, гахайны аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэний судалгааг гаргаж, тухайн байгууллага, өрх айлаас амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрч, эрүүл мэндийн байгууллагад хандсан тохиолдолд халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг баримтлан тусламж, үйлчилгээ үзүүлж, вирус судлалын тандалтад хамруулах.

### **Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр:**

2.1. Эрчимт эмчилгээ, хүүхэд, дотрын тасгийн бэлэн байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг хангаж, амьсгалын аппарат болон нэн шаардлагатай тоног, төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, тасралтгүй байдлыг хангах;

2.2. Хүлээн авах яаралтай тусламжийн тасагт халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах (урсгал зохицуулалт, эрэмбэлэн ангилалт хийх нэмэлт хүний нөөцийг төлөвлөх);

2.3. Сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагад байгаа тоног, төхөөрөмж, вирусийн эсрэг эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, урвалж, оношлуур, сорьц тээвэрлэх орчны нөөцийг бүрдүүлж, тоног төхөөрөмж ашиглалт хэрэглээний судалгааг гаргаж, шаардлагатай тохиолдолд шилжүүлэн ашиглах тооцоолол, төлөвлөлтийг гарган баталгаажуулах;

2.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор хүний нөөцийн судалгааг гаргаж, анагаах ухааны чиглэлээр их, дээд сургуулийн төгсөх

ангийн оюутнууд, ахмад эмч, сувилагчдыг богино хугацааны хурдавчилсан сургалтад хамруулж, тусламж үйлчилгээнд дайчлан ажиллуулах төлөвлөлт, зохицуулалтыг хийх;

2.5. Өнгөрсөн томуугийн улирлын дэгдэлтийн үед ор нэмж дэлгэсэн байдалд үнэлгээ, дүгнэлт хийн өөрсдийн байгууллагын онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргаж, 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө ЭМЯ, ХӨСҮТ-д ирүүлэх;

2.6. Ор дэлгэн ажиллах шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тооцоолол, төлөвлөлт, зохицуулалтыг төлөвлөж, дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах;

2.7. Тусламж, үйлчилгээний урсгал хөдөлгөөнийг зохицуулан, эрэмбэлэн ангилалт хийж, хүнд өвчтөнийг харъяалал харгалзахгүй хэвтүүлэн эмчлэх, вирус судлалын тандалтад сорьц илгээх;

2.8. Томуугийн улирал эхлэх үед томуу, SARS-CoV-2 вирусийн түргэвчилсэн тестийг хэрэглэж, хэрэв эерэг тохиолдолд бх-ПГУ-ын шинжилгээнд баталгаажуулах сорьц авч, шинжилгээний хариуг хүлээлгүйгээр эмчилгээг эхлүүлэх талаар эмч, мэргэжилтэн нарыг сургах, тогтмол хэрэгжүүлэх

2.9. Жирэмсэн эмэгтэй, хүүхэд, ахмад настан, эрхтэн тогтолцооны эмгэг, архаг хууч өвчтэй томуугийн эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гаргаж, алаг цоог дэгдэлтийн үеэс эхлэн сум, тосгон, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч нарын хяналтыг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөөцийг зөв, зохистой хуваарилж хүргэх;

2.10. Эмнэлгийн яаралтай тусламжийн тасгаар үзүүлээд буцсан, эмнэлэгт эмчлүүлээд гарсан хүүхэд болон жирэмсэн эмэгтэй, ахмад настан, архаг суурь өвчтэй хүмүүсийн мэдээллийг өдөр бүр сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд мэдээлж, гэрийн эргэлт, хяналтыг сайжруулах;

2.11. Телемедицин ашиглан шаардлагатай тохиолдолд тусгай мэргэжлийн төвүүдээс зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлэх;

2.12. ТТӨ-ний тархалтын үе шатнаас хамаарч, анхан шатны эрүүл мэндийн байгууллага, дүүргийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар 2025 оны 11 дүгээр сарын 3 дахь долоо хоногоос эхлэн ажиллуулах, амралтын өдрүүдээр ажиллуулах зохицуулалтыг хийх;

2.13. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг нь томуугаас сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж өгөх нээлттэй утсыг 24 цагаар ажиллуулах.

### **Гурав. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр:**

3.1. ТТӨ-ний дэгдэлтийн үед үйлчлүүлэгч, тэдний асран хамгаалагчдад гарын эрүүл ахуйг сахих, хүн хоорондын зай барих, амны хаалт хэрэглэх, зөв ханиалгаж, найтаах зэрэг эрүүл ахуйн зохистой дэглэмийг мөрдөж, амьсгалын замын халдвараас сэргийлэх талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хийх;

3.2. Үйлчлүүлэгч, эрүүл мэндийн ажилтныг гар угаах, халдваргүйжүүлэх, амны хаалт хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай хэрэгслээр хангах;

3.3. Амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийн үзлэгийн өрөө, тусламж үйлчилгээ үзүүлэх хэсгийг бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохгүй байхаар зохион байгуулах;

3.4. Дэгдэлтийн үед эмнэлгийн орох хэсгээс эхлэн амьсгалын замын халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг олон хүнтэй хавьтал болохоос сэргийлж, хөтөч сувилагч, дуугүй хөтөч ажиллуулах;

3.5. Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчдийн дунд амьсгалын замын халдварын шинж тэмдгийг тогтмол тандах;

3.6.Эмнэлэгт хэвтээд тодорхой хугацаа өнгөрсөн, биеийн байдал сайжирсан, эмнэлгээс гарах гэж байгаа эмчлүүлэгчтэй өрөөнд шинэ өвчтөн нэмж авахгүй, өрөө солихгүй байх;

3.7.Тарилга, утлага, шарлага зэрэг эмчилгээг аль болох өвчтөний өрөөнд хийх боломжийг бүрдүүлэх, өвчтөний эмнэлэг доторх хөдөлгөөнийг хязгаарлах;

**Дөрөв. Мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах чиглэлээр:**

4.1.Томуу, томуу тест өвчнөөс сэргийлэх талаар эрсдэлийн харилцаа холбооны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;

4.2.Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд тандалт хийж, эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлэн, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг гаргах;

4.3.Эрсдэлийн үеийн харилцаа холбооны багийг идэвхжүүлж, хүн амын хандлагын судалгаа хийж, судалгаанд үндэслэсэн мэдээлэл сурталчилгаа зохион байгуулах;

4.4.Монголын уламжлалт анагаах ухааны урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих, эмчилгээний чиглэлээр зөвлөмж, мэдээллийг Боловсролын байгууллагууд болон хүн амд хүргэх;

4.5.Харъяа нутаг, дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч, багш, нийгмийн ажилтан, ажилчдад томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварын сэргийлэлт, эрэмбэлэн ангилах, яаралтай тусламжийн чиглэлээр сургалт зохион байгуулах;

**Тав.** Албан даалгаврын хэрэгжилтийг 14 хоног тутам Халдварт өвчин судлалын үндэсний төвийн [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар ирүүлэх.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН